ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	“Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах	Жилийн турш	Дэд хороо
2	Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах (Дотоодод)	I, II улирал	Дэд хороо
3	Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах (Зочин илтгэгч урьж оролцуулах)	III, IV улирал	Дэд хороо
4	Шинээр томилогдсон албан хаагчид чиглүүлэх сургалт зохион байгуулах	Тухай бүр	Дэд хороо, хүний нөөц хариуцсан албан хаагч
5	Байгууллагад үүсч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст зөвлөмж хүргүүлэх	Жилийн турш	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс
6	Дэд хороонд ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгаж шийдвэрлэх	Тухай бүр	Дэд хороо
7	Ёс зүйн гомдол, мэдээлэл, саргасан дүгнэлт, томилох эрх бүхий этгээд зөрчил гаргасан албан хаагчид ёс зүйн хариуцлага тооцсон шийдвэрийг “Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо” цахим системд бүртгэн, мэдээллийн сан бүрдүүлж, нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр хийх.	Жилийн турш	Дэд хорооны нарийн бичиг, хүний нөөц хариуцсан албан хаагч
8	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдох тайлан, мэдээг хүргүүлэх	Улирал бүр	Дэд хорооны нарийн бичиг
9	Дэд хорооны үйл ажиллагааны тайланг дараа оны 1 дүгээр сард багтаан хүргүүлэх	Дараа оны 1 дүгээр сард	Дэд хорооны нарийн бичиг

ДЭД ХОРООНЫ ДАРГА Л.НАНДИНЦЭЦЭГ

ГИШҮҮД Б.СҮНЖИДМӨНХ

Г.САРАНГОО

М.АРХАЛЫХ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Т.БАТ-ЭРДЭНЭ

БАТЛАВ
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ДАРГА Ц.БАТЗУЛ



ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2025 ОНЫ 11,12 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.11.11

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хугацаа	Хариуцах нэгж
Ёс зүйн хороотой хамтран ажиллах хүрээнд					
1	"Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ"-ний судалгааг Ёс зүйн хороотой хамтран зохион байгуулж тус газрын нийт албан хаагчийг судалгаанд хамруулах, судалгааг нэгтгэх, дүгнэх;	-Судалгаанд хамрагдсан албан хаагчийн тоо; -Эрсдэлийн үнэлгээний дүгнэлт боловсруулагдсан байх; -Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулсан байх.	42; 100%; 100%.	XI/11-XII/31	ТЗУГ, ЁДХ
2	Нийт албан хаагчдын хууль зүйн мэдлэг, төрийн албан хаагчийн ёс зүйг сайжруулах зорилгоор “Ёс зүйн хороо”-той хамтран “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалт, уулзалтыг нийт албан хаагчдад зохион байгуулах;	-Зохион байгуулсан сургалтын тоо; -Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо;	1; 39.	XI/11-XI/28	ТЗУГ, ЁДХ
3	Ёс зүйн хорооноос зарласан “Хүндэлье-энэрье” 1 сарын аянд нэгдэж Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчмыг сурталчлах, мэндлэх, талархах, хүндлэх уриалгыг гарган хамт олныг идэвхижүүлэх.	-Зохион байгуулсан арга хэмжээний тоо.	2.	XI/11-XI/28	ТЗУГ, ЁДХ

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр					
4	Ёс зүйн дэд хорооны урамшууллыг олгох асуудлыг шийдвэрлэх;	-Урамшууллыг олгох шийдвэр баталгаажсан байх; -III,IV улирлын урамшуулал олгогдсон хэрэгжилтийн хувь.	1, 100%	XI/11-XII/31	ТЗУГ, ЁДХ
5	"Авлига ашиг сонирхол, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сургалт зохион байгуулах;	-Сургалтын тоо; -Сургалтад хамрагдсан албан хаагчийн эзлэх хувь.	1, 100%	XI/11-XI/28	ТЗУГ, ЁДХ, ЭБАТ
6	"Ёс зүйн сарын аян" зарлаж нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах "Урилга"-ыг бүтцийн нэгжүүдэд хүргүүлэн хамтран ажиллах;	-Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо; -Хамрагдсан албан хаагчийн тоо;	3, 42.	XII/01-XII/31	ТЗУГ, ЁДХ
7	Нийт албан хаагчид болон Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд ажиллаж буй хөндлөгийн бүрэлдэхүүнээр "Ёс зүйн мэдэгдэл" гаргуулан ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;	-Ёс зүйн мэдэгдэл гаргасан албан хаагчийн хувь; -Ёс зүйн мэдэгдэл гаргасан албан хаагчийн тоо.	3, 42.	XII/01-XII/31	ТЗУГ, ЁДХ
8	Байгууллагын нээлттэй мэдээллийн самбарт Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчилах ажлыг тогтмол зохион байгуулах;	-Ажлын 5 хоног тутамд мэдээллийг шинэчилсэн тоо.	5	XII/01-XII/31	ТЗУГ, ЁДХ
9	Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдад төрийн албанд олон жил ажилласан туршлагатай албан хаагчийг томилон чадавхижуулах "Менторшип" арга хэмжээг хэрэгжүүлэх.	-Хөтөлбөрт хамрагдсан албан хаагчийн тоо.	4	XII/01-XII/31	ТЗУГ, ЁДХ
10	Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг Ёс зүйн хороонд хүргүүлэх.	-Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	100%	XII/01-XII/31	ТЗУГ, ЁДХ

БОЛОВСРУУЛСАН:

Ёс зүйн дэд хорооны дарга Д.Нандинцэцэг

Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг М.Батцэнгэл

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төрийн худалдан авах ажиллагааны газрын "Ёс зүйн дэд хороо"-г 2024 оны 325 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. "Ёс зүйн дэд хороо"-ны гишүүн нөхөн томилох тухай 2025 оны А/194, А/287 дугаар тушаалаар хамт олны саналаар хамгийн их санал авсан албан хаагчийг нөхөн томилж 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

ХОЁР.ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:

Арга хэмжээ 2.2.1.1. Байгууллагын ёс зүй, шударга байдлыг төлөвшүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хэлбэр, төрлийг тодорхойлж, төсвийн хамт төлөвлөгөөндөө тусган, хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулах.

-"Ёс зүйн дэд хороо"-ны үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд 2 зорилт 10 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлуулан ажиллах чиглэлийг Ёс зүйн дэд хороонд хүргүүлэн хяналт тавин ажиллаж төлөвлөгөөний хэрэгжилтийг 90.0% гүйцэтгэлтэй тайлагнасан.

Арга хэмжээ 1.2.5.1. Төрийн албан хаагч нь төрийн албаны ёс зүйн хууль, тогтоомжийг эн тэргүүнд чанд мөрдөн, ёс зүйн зарчим, хэм хэмжээ, шаардлагуудыг ёсчлон биелүүлж, ёс зүйн аливаа зөрчилгүй ажиллах соёлыг хэвшүүлэх.

-Тайлант хугацаанд шинээр томилогдсон 9 албан хаагчид "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" хуулийн мэдлэг олгох арга хэмжээг зохион байгуулж, 1 албан хаагчаас ирүүлсэн гомдлыг хэлэлцэж, дүгнэлтийг томилох эрх бүрхий албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлэсэн;

-Хууль дээдлэх, тэгш, шударга, хариуцлагатай, албан үүрэгт нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид, ёс зүй, хэм хэмжээг сахин ажиллах "Ёс зүйн мэдэгдэл"-ийг боловсруулан, худалдан авах ажиллагаа зохион байгуулах үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүд, албан хаагч тус бүрд танилцуулан, гарын үсгээр баталгаажуулан үйл ажиллагаандаа зарчим болгон ажиллана;

Арга хэмжээ 2.2.3.2. төрийн албаны ёс зүйн тайлбар, гарын авлага, зөвлөмж зааврыг төрийн албан хаагчдад түгээх, сурталчилах, мэдээлэх ажлыг зохион байгуулах.

-Ёс зүйн хорооноос зохион байгуулж буй "Хүндэлье, энэрье" сарын аянд нэгдэж, төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн зарчмыг таниулах зорилготой зурагт хуудас хийж, дотоод сүлжээ болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулж, албан хаагчдад уриалга хүргэсэн.

-12 дугаар сард "Ёс зүйн сарын аян" зарлаж нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах тухай "Урилга"-ыг бүтцийн нэгжүүдэд хүргүүлэн ажилласнаар "Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтэг хэм хэмжээ"-г Монгол ардын зүйр 9 цэцэн үгээр зүйрлэн илэрхийлж, хоногшуулах арга хэмжээ зохион байгуулж, тараах материал, богино хэмжээний видео шторк бүтээж нийт албан хаагчдад түгээж ажилласан;

Арга хэмжээ 2.1.1.1. Ажлын байран дахь ёс зүйн сургалтыг зохион байгуулах, сургалтын үр дүнг мэдээлэх.

-2025.11.18-ны өдөр "Ёс зүйн хороо"-ны Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүү, Ажлын албаны дэд хороо хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Мөнхжин нарыг урьж "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, Ёс зүйн зөрчил бүртгэл хяналтын дэд систем", "Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж" сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 20 албан хаагчийг хамруулсан;

-Төрийн албаны зөвлөлийн 2025.11.13-ны өдөр “7:4:10” мэдээллийн цагаар танилцуулсан “Ёс зүйн төлөв байдал, эрсдэлийн үнэлгээний арга зүйн асуудал” сэдэвт сургалтад 10 албан хаагч хамрагдсан.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

-Байгууллагын “Ёс зүйн дэд хороо”-ны үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд байгууллагын удирдлага манлайлал үзүүлж 2 зорилт 10 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжин ажилласан;

-Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ"-ний судалгаанд 42 албан хаагч буюу 100 хувь хамруулах үйл ажиллагаанд удирдлагын манлайлал үзүүлэн дэмжиж ажилласан;

-Ёс зүйн дэд хорооны урамшууллыг олгох асуудлыг шийдвэрлэхээр төлөвлөгөөнд тусгагдсан боловч ЗГ-ын хэмнэлтийн бодлогын хүрээнд тус асуудал шийдвэрлэх боломжгүй болсон. Иймд ЗГ-аас шийдвэрлэсэн нөхцөлд олгож эхлэхээр хүлээгдэж байна.

2.3.Ёс зүйн хорооны үйл ажиллагаа:

Байгууллагын “Ёс зүйн дэд хороо”-ны үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд 2 зорилт 10 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлуулан ажиллаж төлөвлөгөөний хэрэгжилтийг 90.0% гүйцтгэлтэй тайлагнасан.

Төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллав. Үүнд:

-Тайлант хугацаанд шинээр томилогдсон 9 албан хаагчид “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хуулийн мэдлэг олгох арга хэмжээг зохион байгуулж, 1 албан хаагчаас ирүүлсэн гомдлыг хэлэлцэж, дүгнэлтийг томилох эрх бүрхий албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлэсэн. Мөн Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системд дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан;

-Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ"-ний судалгаанд 42 албан хаагч буюу 100 хувь хамруулсан. Судалгааг нэгтгэн Ёс зүйн хороонд хүргүүлж, өгсөн чиглэлийн дагуу ажиллаж байна. Тус судалгааны үр дүнд Ёс зүйн дэд хорооноос 2026 онд “Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулан, батлуулж ажиллана;

-Төрийн албаны зөвлөлийн 2025.11.13-ны өдөр “7:4:10” мэдээллийн цагаар танилцуулсан “Ёс зүйн төлөв байдал, эрсдэлийн үнэлгээний арга зүйн асуудал” сэдэвт сургалтад 10 албан хаагч хамрагдсан;

-Ёс зүйн хорооноос зохион байгуулж буй “Хүндэлье, энэрье” сарын аянд нэгдэж, төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн зарчмыг таниулах зорилготой зураг хуудас хийж, дотоод сүлжээ болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулж, албан хаагчдад уриалга хүргэсэн;

-2025.11.18-ны өдөр Ёс зүйн хорооны Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүү, Ажлын албаны дэд хороо хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Мөнхжин нарыг урьж “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, Ёс зүйн зөрчил бүртгэл хяналтын дэд систем”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж” сэдэвт сургалтыг зохион байгуулсан 20 албан хаагчийг хамруулсан;

-Хууль дээдлэх, тэгш, шударга, хариуцлагатай, албан үүрэгт нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид, ёс зүй, хэм хэмжээг сахин ажиллах "Ёс зүйн мэдэгдэл"-ийг боловсруулан, худалдан авах ажиллагаа зохион байгуулах үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүд, албан хаагч тус бүрд танилцуулан, гарын үсгээр баталгаажуулан үйл ажиллагаандаа зарчим болгон ажиллана;

- 12 дугаар сард “Ёс зүйн сарын аян” зарлаж нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах “Урилга”-ыг бүтцийн нэгжүүдэд хүргүүлэн хамтран ажиллаж Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтэг хэм хэмжээг Монгол ардын 9 зүйр цэцэн үгээр зүйрлэн хоногшуулах арга хэмжээ зохион байгуулж, тараах материал, богино хэмжээний видео шторк бүтээж нийт албан хаагчдад хүргүүлэн шторкийг дотоод сүлжээгээр түгээж ажилласан;

-Ёс зүйн дэд хорооны урамшууллыг олгох асуудлыг шийдвэрлэхээр төлөвлөгөөнд тусгагдсан боловч ЗГ-ын хэмнэлтийн бодлогын хүрээнд тус асуудал шийдвэрлэгдээгүй байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
-Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг дэмжих удирдлагын манлайлал дээшилсэн; -Төрийн албан хаагчдад сургалт, аянг зохион байгуулснаар Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн хэм хэмжээний ойлголт дээшилсэн; -Ёс зүйн дэд хороонд ирүүлсэн гомдол маргааныг шийдэрлэх үйл ажиллагаа хийгдэснтэй холбогдуулан албан хаагчдын мэдлэг, ёс зүйн хэм хэмжээг баримтлах байдал дээшилсэн.	-Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшуулал олгогдохгүй байгаа тул гишүүд төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд идэвх сул, үндсэн ажлаас хойгуур тавих асуудал тулгарч байна. -Мэргэжил, арга зүйгээр хангагдах байдал дутмаг.
Санал:	
Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшууллыг олгож дэд хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх;	

Шалгах хэсэг:

☑ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

ТОМИЛОХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

ДАРГА Ц.БАТЗУЛ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА Л.НАНДИНЦЭЦЭГ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧИГ М.БАТЦЭНГЭЛ

2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
2025 ОНЫ "ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	1	10
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0,5	0,5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0,5	0,5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0,5	0	0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0,5	0,5	5
Хэсгийн оноо				**4**	**3,5**	**35**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх		1	0	0
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	0	0
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	0	0
Хэсгийн оноо				**3**	**0**	**0**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	30
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**6,5**	**65**

ТАНИЛЦСАН:
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА **Ц.БАТЗУЛ**

БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН **Б.БОЛОРЦЭНГЭЛ**